

2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ КВАНЖУ ИХ СУРГУУЛИЙН СОЛОНГОС ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ ХӨТӨЛБӨРИЙН ЭЛСЭЛТИЙН УДИРДАМЖ



GWANGJU
UNIVERSITY

Office of International



Website



Instagram



광주대학교
GWANGJU UNIVERSITY

1. Солонгос хэлний сургалтын хөтөлбөрийн танилцуулга

- Хичээлийн мэдээлэл
 - Улирлын зохион байгуулалт
 - Жилд 4 улиралтай. Нэг улирал нь 10 долоо хоног үргэлжлэх бөгөөд нийт 200 цагийн хичээл орно
 - Хичээлийн хуваарь
Долоо хоногт 5 өдөр (Даваа-Баасан), өдөрт 4 цаг хичээллэнэ. (1 цагийн хичээл = 50 минут)
 - Сургалтын агуулга
Түвшин тогтоох шалгалтын үр дүнд үндэслэн анги хуваарилж, унших, бичих, сонсох, ярих, үгсийн сан болон дүрмийн сургалт явуулна.
- Соёлын туршлага
 - Солонгосын соёлтой танилцах боломж
Түүхэн дурсгалт газруудаар аялах, уламжлалт соёлын үйл ажиллагаанд оролцох, K-POP бүжиг болон соёл суралцах зэрэг хөтөлбөрүүд зохион байгуулагдана.

2. Сургалтын хуваарь

Улирал	Сургалтын хугацаа
Хавар	2026.03.03.~05.12.
Зун	2026.05.26.~08.05.
Намар	2026.09.01.~11.13.
Өвөл	2026.11.23.~2027.02.02.

3. Солонгос хэлний бэлтгэл хөтөлбөрийн суралцагчдад зориулсан дэмжлэгийн үйлчилгээ

- Солонгосын амьдралд дасан зохицох хөтөлбөр (менторинг, соёлын туршлага зэрэг)
 - Аюулгүй ажиллагааны сургалт (зүрх уушгины сэхээн амьдруулах анхны тусламж гэх мэт), гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт
 - Оюутны клуб, дугуйлангийн үйл ажиллагаанд оролцох боломж
 - Бусад үйлчилгээ
 - Дотуур байранд орох бүртгэл
 - Гадаадын иргэний бүртгэл
 - Банкны данс нээхэд дэмжлэг үзүүлэх
 - Номын сангийн үйлчилгээ ашиглахад туслах

4. Бүртгэлийн үйл явц

- Баримт бичиг бүрдүүлэх (шуудангаар эсвэл биечлэн)
 - Баримт бичиг болон ярилцлагын шалгаруулалт
 - Тэнцсэн суралцагчдыг зарлах
 - Сургалтын төлбөр төлөх
 - Стандарт элсэлтийн зөвшөөрлийн бичиг олгох / Виз мэдүүлэх
 - БНСУ-д нэвтрэн ирэх

5. Бүрдүүлэх материал

- Элсэх өргөдөл
- Суралцах төлөвлөгөө
- Өөрийн танилцуулга
- Сургалтын зардал хариуцах баталгааны бичиг
- Хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах, дамжуулах зөвшөөрлийн маягт
- Паспорт болон иргэний үнэмлэхний хуулбар
- Гэр бүлийн бүртгэлийн лавлагаа
- Гадаадын иргэний үнэмлэхний хуулбар (хамаарах тохиолдолд)
- Хамгийн сүүлд төгссөн сургуулийн диплом болон дүнгийн тодорхойлолт
- Боловсролын баримт бичгийн баталгаажуулалт (Апостиль эсвэл БНСУ-ын гадаад дахь дипломат төлөөлөгчийн газрын консулын баталгаажуулалтын эх хувь)
- Боловсролын зэрэг, боловсролын баримт бичгийн баталгаажуулалтын тайлан
- Солонгос болон англи хэлээс бусад хэл дээрх баримт бичгийг солонгос эсвэл англи хэлээр орчуулж, нотариатаар баталгаажуулсан хувийг ирүүлэх
- Санхүүгийн баталгааны баримт (8,000,000 воноос дээш үлдэгдэлтэй банкны дансны тодорхойлолт)
- Эцэг эхийн ажлын газрын тодорхойлолт болон орлогын баталгаа

6. Элсэлтийн хуваарь

- Намрын улирал
- Бүртгэлийн хугацаа: 2026.06.08 (Даваа) ~ 2026.06.19 (Баасан)
- Өвлийн улирал
- Бүртгэлийн хугацаа: 2026.09.07 (Даваа) ~ 2026.09.18 (Баасан)

Кванжу их сургуулийн солонгос хэлний
сургалтын хөтөлбөрийн лавлах

Монгол: ☎ 062-670-2569

E-MAIL: mongolia@gwangju.ac.kr

FAX: 062-670-2733

Вэбсайт: <http://ie.gwangju.ac.kr>

Хаяг: БНСУ, Кванжу хот, Нам-гу дүүрэг, Хёдокро 277, Хосим барилгын 6 давхар, ОУ-ын хамтын ажиллагааны алба (Шуудангийн код: 61743)

7. Анхаарах зүйлс

- Өргөдөл гаргагч нь бүх материалыг эх хувиар бүрдүүлж өгөх ёстой. Имэйлээр өргөдөл илгээсэн тохиолдолд эх хувийн материалыг заавал дараах хаягаар шуудангаар илгээнэ. БНСУ, Кванжу хот, Нам-гу дүүрэг, Хёдокро 277, Кванжу их сургууль, Хосим барилгын 6 давхар, Олон улсын хамтын ажиллагааны алба (Шуудангийн код: 61743)
- Солонгос хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцагч нь 1 жил (4 улирал)-ийн сургалтад заавал бүртгүүлнэ.
- Бүрдүүлэх материал дутуу, өргөдлийн маягт буруу бөглөсөн, элсэлтийн журам мөрдөөгүй, хаяг болон холбоо барих мэдээлэл тодорхой бус зэрэг шалтгаанаас үүдэн гарах аливаа хохирлыг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.
- Өргөдлийн материалаар мэдээллийг баталгаажуулах боломжгүй тохиолдолд нэмэлт материал шаардаж болох бөгөөд шаардлагатай материал дутуу бол сонгон шалгаруулалтаас хасагдаж болно.
- Өргөдөл гаргагч нь элсэлтийн хугацаанд Кванжу их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны албаны мэдээлэл, мэдэгдлийг тогтмол шалгаж, өгсөн зааврыг мөрдөх үүрэгтэй. Холбоо тасарснаас үүсэх аливаа хариуцлагыг өргөдөл гаргагч өөрөө хүлээнэ.
- Өргөдлийн материалаар мэдээллийг баталгаажуулах боломжгүй тохиолдолд нэмэлт материал шаардаж болох бөгөөд шаардлагатай материал дутуу бол сонгон шалгаруулалтаас хасагдаж болно.
- Өргөдөл гаргагч нь элсэлтийн хугацаанд Кванжу их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны албаны мэдээлэл, мэдэгдлийг тогтмол шалгаж, өгсөн зааврыг мөрдөх үүрэгтэй. Холбоо тасарснаас үүсэх аливаа хариуцлагыг өргөдөл гаргагч өөрөө хүлээнэ.
- Баримт бичиг хуурамчаар үйлдэх, өөр хүнийг ярилцлагад оролцуулах зэрэг зөрчил илэрвэл элсэлтийн эрх болон суралцах эрхийг хүчингүй болгоно.
- Сонгон шалгаруулалтын үнэлгээ болон тэнцээгүй шалтгааныг нийтэд мэдээлэхгүй.
- Өргөдөлтэй хамт ирүүлсэн материалыг буцаан олгохгүй.
- Элсэлтийн сонгон шалгаруулалт дууссаны дараа виз авах болон визийн ангилал өөрчлөхтэй холбоотой нэмэлт материал шаардагдаж болно.
- Элсэх зөвшөөрөл олгосны дараа эрх хасах нөхцөл илэрсэн эсвэл виз олгохоос татгалзсан тохиолдолд элсэлтийг хүчингүй болгоно.

8. Солонгос хэлний бэлтгэл хөтөлбөрийн суралцагчдад зориулсан дэмжлэгийн хөтөлбөр



- Солонгосын уламжлалт урлаг, соёлын тоглолт үзэж танилцах



- Усан парк (Water Park) аялал, туршлага



- Ханбук өмсөж үзэх соёлын хөтөлбөр



- Оюутны клуб, дугуйлангийн үйл ажиллагаанд оролцох



- Сэдэвчилсэн тоглоомын парк үзэх (Everland, Gyeongju World зэрэг)



- Жэжү арлын соёлын танилцах аялал